



Ахлагчдын чуулга
ба Халамжийн
нийгэмлэгт
зориулсан

ИРЭЭД, НАМАЙГ ДАГА ХӨТӨЛБӨР

*Эдгээр материалыг Gospel Library
аппликэйшн болон comefollowme.lds.org
вэбсайт дээрээс үзэх боломжтой.*

Бидэнд яагаад

Ахлагчдын чуулгын болон Халамжийн ний- гэмлэгийн цуг- лаан байдаг вэ?

Энэ хожмын өдрүүдэд Бурхан авралын ажлаа гүйцэлдүүлэхдээ туслуулахаар санваарыг сэргээж, санваарын чуулгуудыг болон Халамжийн нийгэмлэгийг зохион байгуулсан. Тиймээс бид ням гараг бүр ахлагчдын чуулгын болон Халамжийн нийгэмлэгийн цуглаануудад цугларахдаа Бурханы ажлыг гүйцэлдүүлэхэд туслахын тулд юу хийхээ ярилцаж мөн төлөвлөдөг. Үр дүнтэй байхын тулд эдгээр цуглаан нь зүгээр нэг хичээлээс ч илүү байх ёстой юм. Эдгээр цуглаан нь авралын ажлын талаар зөвлөлдөх, энэ ажлын талаар Сүмийн удирдагчдын заасан сургаалуудаас хамтдаа суралцах, үүнийг гүйцэлдүүлэхийн тулд төлөвлөж, өөрсдийгөө зохион байгуулах боломжууд юм.



Эхний ням гаргийн

зөвлөлийн хурал

Сар бүрийн эхний ням гарагт ахлагчдын чуулгын болон Халамжийн нийгэмлэгийн цуглаан дээр *багш хичээл заахгүй*. Үүний оронд ахлагчдын чуулга, Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөдүүд зөвлөлийн хурлуудыг удирдан явуулна. Эхний ням гаргийн зөвлөлийн хурлууд дээр ахлагчдын чуулга болон Халамжийн нийгэмлэг тус бүр орон нутагтаа хүлээсэн үүрэг, боломж, бэрхшээлтэй асуудлуудаа хамтдаа зөвлөлдөн; бие биенийхээ санаа бодол, туршлагаас суралцаж; Сүнснээс авсан сүнслэг өдөөлтийнхөө дагуу үйлдэх арга замуудыг төлөвлөдөг. Эдгээр ярилцлага нь холбогдох судрууд, амьд бошиглогчдын сургаалд тулгуурласан байх ёстой.

Бүх зөвлөлийн хурал адилгүй байх болно. Зөвлөлийг амжилттай удирдахад нь ерөнхийлөгчийн зөвлөдүүдэд туслах зарим удирдамжийг доор өгүүлэв.



ЭХНИЙ НЯМ ГАРГИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН СЭДВҮҮД

Зөвлөлийн хурлаар хэлэлцэх сэдвүүд ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал, бүсийн төлөвлөгөө, удирдагчдын гишүүдэд тохинуулж байхдаа олж авсан сэтгэгдэл, Ариун Сүнсний өдөөлтөөс ирж болно. Доорх сэдвүүд санаа авахад зориулагдсан. Удирдагчид ярилцвал зохих бусад хэрэгцээг мэддэг байж болох юм.

- Бид эргэн тойрондоо буй хүмүүстээ тохинуулахын тулд юу хийж болох вэ? (Мозая 23:18-ыг үзнэ үү).
- Бид өөр өөр үүрэг хариуцлагаа чухал ач холбогдлоор нь хэрхэн ялгах вэ?
- Бид сайн мэдээг найз нөхөд, хөршүүдтэйгээ хэрхэн хуваалцах вэ? (Алма 17-г үзнэ үү.)
- Бид өөрсдийгөө болон гэр бүлээ зохисгүй мэдээллийн хэрэгсэл, порнографаас хэрхэн хамгаалах вэ?
- Бид тойргийнхоо хүүхдүүдэд болон өсвөр үеийнхэнд зөвлөж, тэднийг хүчирхэгжүүлэхийн тулд юу хийх вэ?
- Бид гэр бүлийн түүхийн ажилд болон ариун сүмийн шүтлэг бишрэлд хэрхэн илүү сайн оролцож чадах вэ?
- Бид сайн мэдээний талаарх асуултынхаа хариултыг авахаар мөн сайн мэдээг илүү гүн ойлгохоор хичээх явцдаа Их Эзэний тусламжийг хэрхэн урьж чадах вэ?
- Бид Их Эзэний болон Түүний сайн мэдээний талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлж, гэр бүлээ сүнслэг байдлын хувьд илүү бие даасан байхад хэрхэн тусалж чадах вэ?

ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ӨМНӨ

Хийж болох зүйлс:

- Орон нутгийн хэрэгцээ, боломж, бэрхшээлүүдийг таньж мэдэх.
- Ярилцах сэдвээ залбирч сонгох.
- Чуулгын гишүүдийг эсвэл Халамжийн нийгэмлэгийн эгч нарыг бодол санаа, гэрчлэлээ хуваалцахаар бэлтгэн ирэхэд урих.

Хийж болохгүй зүйлс:

- Хичээл бэлдэх.
- Тодорхой шийдэл эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ирэх.

ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ҮЕЭР

Хийж болох зүйлс:

- Гишүүдийг өмнөх хурлуудаас төрсөн сэтгэгдэл болон төлөвлөгөөний дагуу үйлдэхэд тохиолдсон **ТУРШЛАГААСАА ХУВААЛЦАХАД** урих.
- Хурлын сэдвийг танилцуулж, гишүүдийг уг сэдвийн талаар **ХАМТДАА ЗӨВЛӨЛДӨН**, судрууд, бошиглогчдын үгсээс болон Ариун Сүнснээс шийдэл мөн удирдамж эрэлхийлэх.
- Хэлэлцсэн зүйлийнхээ дагуу **ҮЙЛДЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ**. Үүнд бүлгийн эсвэл хувь хүний өөрөө хийсэн төлөвлөгөөнүүд орж болно.

Хийж болохгүй зүйлс:

- Харилцан ярианд давамгайлах.
- Өөрийн санаа бодлыг бусдад итгүүлэхийг оролдох.
- Нууцлаг асуудлуудын талаар ярилцах.
- Хичээл заах.
- Хэн нэгнийг оролцуулахаар дарамт үзүүлэх.

ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ДАРАА

Хийж болох зүйлс:

- Зөвлөлийн хурлын үеэр гарсан төлөвлөгөө, даалгаврын гүйцэтгэлийг шалгах.
- Дуудлагынхаа улмаас эсвэл бусад шалтгаанаар хуралд оролцож чадаагүй хүмүүсийг хамруулах арга замыг олох мөн гарсан төлөвлөгөөнүүдийн талаар тэр хүмүүст мэдээлэх.
- Гишүүдэд дараагийн хурлууд дээр туршлагаасаа хуваалцах боломж олгох.

“Энэхүү зөвлөлийн хурлын хамгийн сайхан зүйлсийн нэг бол та нар хурлын төгсгөлд үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргадаг нь юм.”

—Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам эгч



Хоёр ба гурав дахь ням гаргийн

цуглаанууд

Сар бүрийн хоёр ба гурав дахь ням гарагт ахлагчдын чуулгууд болон Халамжийн нийгэмлэгийнхэн хамгийн сүүлийн Ерөнхий чуулганы Сүмийн удирдагчдын сургаалаас судална. *Тэргүүн Зөвлөлийн болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн захиаст онцлон анхаарах ёстой.* Гэхдээ орон нутгийн хэрэгцээ, Сүнсний нөлөөнд тулгуурлан, хамгийн сүүлийн Ерөнхий чуулганы ямар ч захиасыг ярилцаж болно.

Бишоп эсвэл гадасны ерөнхийлөгч санал болгож болох ч ихэнх тохиолдолд ахлагчдын чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөл гишүүдийн хэрэгцээнд тулгуурлан судлах чуулганы захиасыг сонгоно. Удирдагчид эхний ням гаргийн зөвлөлийн хурал дээр хэлэлцсэн сэдэвтэй холбоотойгоор эсвэл Сүнсний удирдамжаар өөр захиас сонгож болно.

Удирдагчид болон багш нар гишүүдийг сонгосон захиасыг урьдчилан уншиж, сайн мэдээний үнэнүүд мөн тэдгээр үнэний дагуу хэрхэн үйлдэх талаарх санаа бодлоо хуваалцах бэлтгэлтэй ирэхэд урамшуулах арга замуудыг олох ёстой. Доор санал болгосон суралцах үйл ажиллагааг *Аврагчийн арга барилаар заах нь* товхимол дээрх зарчмууд дээр үндэслэн боловсруулсан бөгөөд Ерөнхий чуулганы захиасуудаас суралцахад нь гишүүдэд туслах болно.

“[Ерөнхий чуулганы] захиасыг гэр бүлийн үдшээр болон сайн мэдээг заахдаа мөн гэр бүлийнхэн, найз нөхөдтэйгөө ярилцахдаа ашиглаж болох арга замыг шамдан эрэлхийл.”

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, “Үргэлжлүүлцгээе хамтдаа,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган.

М.Рассэлл Баллард, “Бурханы үнэ цэнтэй бэлгүүд”

Ерөнхийлөгч Баллардын захиас бошиглогчид болон Христэд итгэх итгэл, ариун ёслол, үйлчлэл зэрэг олон сэдвийг хамарсан бөгөөд танай чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн гишүүдэд өөр өөр сэдэв илүү ач холбогдолтой байж болох юм. Гишүүдийг энэ захиасаас өөрсдөд нь сүнслэгээр нөлөөлж буй ямар нэгэн зүйлийг хуваалцахад урь. Ерөнхийлөгч Баллардын захиасаас бид ямар ямар урилгыг эсвэл амлагдсан адислалыг олж болох вэ? Гишүүдийг энэ ярилцлагын үр дүнд юу хийхээр сүнслэгээр нөлөөлөгдсөн талаараа хэдэн минут тунгаан бодоход урихад анхаар.

Гари И.Стивэнсон, “Бошиглогчийн зүрх сэтгэл”

Та гишүүдэд шинэ бошиглогчийн дуудлагын “ач холбогдлыг ойлгоход” туслахын тулд тэднийг энэхүү тэнгэрлэг үйл явцын ач холбогдол, ариун нандин байдлыг ойлгоход нь туслах үнэнүүд болон санаа бодлыг ахлагч Стивэнсоны захиасаас эрж хайхад урьж болно. Гишүүдийг ерөнхийлөгч Нэлсонг Сүмийн ерөнхийлөгчөөр дэмжин баталсан онцгой ариун хуралдайн үеэр мэдэрсэн зүйлийнхээ тухай хуваалцахад урих талаар бодож үз. Та мөн самбарт зүрх зураад, түүн дотор ерөнхийлөгч Нэлсоний зүрх сэтгэл, зан байдлыг дүрсэлсэн үг хэллэгүүдийг бичихийг гишүүдээс хүсэж болох юм. Түүний заасан ямар зүйл биднийг адисалсан бэ?

Нийл Л.Андэрсэн, “Бурханы бошиглогч”

Ахлагч Андэрсэны захиасыг ярилцах нь гишүүдийн амьд бошиглогчид итгэх итгэлийг хүчирхэгжүүлэх болно. Та тэднийг түүний захиасаас Бурхан яагаад дэлхий дээр бошиглогчидтой байдаг, бид яагаад бошиглогчдыг дагадаг болохыг ойлгоход нь туслах ямар нэгэн зүйлийг эрж хайхад урьж болох юм. Бидэнд бошиглогч байгаа учраас бид хэрхэн адислагдсаар байгаа вэ? Гишүүд ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсонг Их Эзэний бошиглогч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхийлөгч гэсэн гэрчлэлийг хэрхэн олж авснаа хуваалцаж болно.

Дэвид А.Бэднар, “Зүрх сэтгэлдээ номхон дөлгөөн”

Ахлагч Бэднарын захиасын талаар ярилцлага өрнүүлэхийн тулд, та самбарт *Номхон дөлгөөн байдал бол . . . мөн. Номхон дөлгөөн байдал бол . . . биш* гэж бичиж болох юм. Дараа нь гишүүд ахлагч Бэднарын захиасыг судалж, эдгээр өгүүлбэрийг гүйцээх хэллэгүүдийг олоод самбарт бичиж болно. Бид энэ захиасаас илүү номхон дөлгөөн байхад маань сүнслэгээр нөлөөлөх юуг олж мэдэж болох вэ? Номхон дөлгөөн байдлын ямар жишээ та нарт бодогдож байна вэ? Бид ахлагч Бэднарын илүү номхон дөлгөөн болох тухай зөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

Бонни Л.Оскарсон, “Залуу эмэгтэйчүүд энэ ажилд”

Асуултууд нь тунгаан бодоход урих нэг арга зам юм. Оскарсон эгчийн захиаст хариулт нь байгаа *Бид Их Эзний ажилд залуу эмэгтэйчүүдийг хэрхэн оролцуулах вэ?* зэрэг хэдэн асуултыг самбарт бичих талаар бодож үз. Ангийн гишүүдийг эдгээр асуултын хариултыг түүний захиасаас хайж олоод, ойлгож мэдсэнээ хуваалцахад урь. Залуу эмэгтэйчүүд тохинуулалд оролцсоноор ямар ямар адислал ирдэг вэ? Ангийн гишүүдээс залуу эмэгтэйчүүдийн хамт тохинуулсан туршлагаасаа хуваалцахыг хүс. Бид ярилцлагадаа тулгуурлан юу хийхийг сүнслэгээр мэдэрч байна вэ?

Дэйл Г.Рэнланд, “Гэр бүлийн түүх, ариун сүмийн ажил: Лацдан холболт ба эдгээлт”

Ахлагч Рэнланд ус цутган гарч ирж байгаа ариун сүмийн талаарх Езекиелийн үзэгдлийн тухай ярьсан (Езекиел 47:8–9-ийг үзнэ үү). Чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн нэг гишүүн энэ үзэгдлийн зургийг самбарт зурж болно. Ариун сүм, гэр бүлийн түүхийн ажлын адислалууд нь хэрхэн Езекиелийн үзэгдлийн нэгэн адил ажилладаг вэ? Та ангийн гишүүдийг өөрсдөд нь тохиолдсон ариун сүм, гэр бүлийн түүхийн ажлын адислалуудын талаар хуваалцахад урьж болно. Бид ариун сүм, гэр бүлийн түүхийн ажлыг амьдралынхаа нэг хэсэг болгохын тулд юу хийж чадах вэ?

Д.Тодд Кристоффэрсон, “Ахлагчдын чуулга”

Ахлагчдын чуулгад, та чуулгын гишүүдийг ахлагч Кристоффэрсоны захиасаас “Эдгээр өөрчлөлтийн зорилго” гэсэн гарчиг



бүхий хэсгийг уншихад урьж болох юм. Бид эдгээр зорилгод хүрэхээ батлахын тулд юу хийж чадах вэ? Халамжийн нийгэмлэгт, та хэн нэгнээс ахлагч Кристоффэрсоны тайлбарласан Мелкизедек санваарын чуулгын өөрчлөлтүүдийг товчлон ярихыг хүсэж болно. Ингэснээр эгч нар эдгээр өөрчлөлтөд агуулагдах танай Халамжийн нийгэмлэгийн ажилд хэрэгжүүлж болох зарчмуудыг таньж мэднэ. Ахлагчдын чуулга эсвэл Халамжийн нийгэмлэгт гишүүд Гоатэс ахын түүхээс ойлгож мэдсэнээ, энэ нь тэдний ажилд хэрхэн хэрэгжиж болохыг ярилцаж болно.

Роналд А.Расбанд, “Харцгаа! Хааны арми”

“Харцгаа! Хааны арми” (Сүмийн дуулал, ху. 251) дууллыг хамтдаа дуулах эсвэл сонсох юм уу үгийг унших нь ахлагч Расбандын захиасын тухай ярилцлагыг өрнүүлж магадгүй юм. Санваарын чуулгууд болон Халамжийн нийгэмлэг нь хэрхэн хааны армитай адил вэ? Гишүүд мөн ахлагч Расбандын дурдсан санваарын чуулгуудын шинэ зохион байгуулалтаас ирэх “олон адислалыг” олж хараад, ярилцаж болно. Эдгээр өөрчлөлтийг хэрэгжүүлснээр бидний хүлээн авсан эсвэл хүлээн авахыг найдаж байгаа бусад ямар адислал байдаг вэ? Халамжийн нийгэмлэг “олон төрлийн авьяас билиг” болон “зааж сургах явдал” зэрэг адислалуудыг хэрхэн илүү бүрэн дүүрэн хүлээн авч болох вэ?

Хэнри Б.Айринг, “Сүнсээр өдөөгдсөн тохинуулал”

Ерөнхийлөгч Айринг өөрт нь гүн сэтгэгдэл үлдээсэн тохинууллын тухай хоёр ариун ёслолын цуглаан дээрх үгийн талаар ярьсан. Та чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн гишүүдийн нэг хэсгийг 14 настай хөвгүүний үгийг, нөгөө хэсгийг гэрийн багшийн тухай түүхийг авч үзэхийг хүсэж болно. Тэд унших үедээ хэн нэгэнд тохинуулахаар шинээр томилогдсон залуу эрэгтэй эсвэл залуу эмэгтэйд өгч болох зөвлөгөөг бодож болох юм. Бид хэрхэн “тохинууллын үйлчлэлдээ . . . илүү сүнсээр өдөөгдсөн, илүү энэрэнгүй [байх]” вэ?

Даллин Х.Өүкс, “Санваарын хүч”

Ярилцлагыг эхлүүлэхийн тулд ерөнхийлөгч Өүксийн захиасын дөрвөн хэсгийн гарчгийг самбарт бичиж болох юм. Тэгээд гишүүн бүрийг нэг хэсгийг чимээгүй уншаад, тухайн хэсгийн гол захиасыг нэгтгэсэн нэг өгүүлбэрийг самбарт бичихэд урь. Гишүүд уншсан зүйлийнхээ улмаас юу хийхээр сүнслэгээр нөлөөлөгдсөнөө хуваалцаж болно. Бид ерөнхийлөгч Өүксийн захиаст байгаа сургаалуудыг хэрэгжүүлснээр санваартны эсвэл Халамжийн нийгэмлэгийн эгч нарын хувьд үйлчлэлээ хэрхэн сайжруулах вэ?

Рассэлл М.Нэлсон, “Бурханы хүч, эрх мэдлээр тохинуулах нь”

Ерөнхийлөгч Нэлсон санваартнуудыг “өндийн босож”, Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг адислахад санваараа ашиглахад урьсан. Чуулгынхаа эсвэл Халамжийн

Бидний цуглааны загвар

1. Өмнөх (ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүний удирдан явуулсан) санваарын эсвэл Халамжийн нийгэмлэгийн цуглаануудад хүлээн авсан сүнслэг өдөөлт, урилгын дагуу үйлдсэн **туршлагуудаа хуваалц**.

2. **Хамтдаа суралц** (дуудагдсан багшийн удирдлаган доор).

Гишүүдийг дараах алхмуудыг хэрэгжүүлэхэд урих нь ихэнх тохиолдолд тустай байдаг.

- а. Чуулганы захиасаас ямар нэгэн зүйлийг эрж хай (тухайлбал, асуултын хариулт, сүнслэгээр нөлөөлөх хэсэг, зарчмын жишээ гэх мэт).
- б. Тэдний олж мэдсэн зүйлийг нь хуваалцуулж, ярилц.
- в. Тухайн захиас тэдний амьдрал, туршлагад хэрхэн хэрэгжих талаар бодож үз.

3. Ганцаарчлан эсвэл бүлгээр **үйлдэх төлөвлөгөө гарга** (ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээр удирдуулна).

нийгэмлэгийн гишүүдийг түүний ярьсан жишээнүүдийг хайж олоод, тэдгээр нь санваар тэдний гэр бүл болон бусдыг адислахад ашиглагдаж болохыг ойлгоход бидэнд хэрхэн туслах талаар ярилцахад урь. Санваарын хүчээр адислагдсан үедээ бид ямар туршлагыг хуваалцаж болох вэ? “Бурханы нэрээр тохинуулахын” тулд Түүний санваарыг ашиглах итгэлтэй байхад бусдад эсвэл өөрсдөдөө бид хэрхэн тусалж чадах вэ?

Рэйна И.Абурто, “Нэг санаагаар”

Абурто эгчийн захиас нь танай чуулгын ханд эсвэл Халамжийн нийгэмлэгийнхэнд Их Эзэний ажлыг хийхдээ эер сайн нэгдмэл байгаагаа дүгнэж цэгнэх боломжийг олгодог. Гишүүдийг үүнийг хийхэд туслахын тулд та хаан эрвээхийнүүд, Аврагчийн нифайчууд дээр айлчлан очсон (*Сайн мэдээний*

зургийн цуглуулга, 82, 83, 84) болон Сүмийн хүмүүнлэгийн ажлын зургуудыг (LDS.org-ыг үзнэ үү) харуулж болно. Гишүүд захиасыг судалж, Абурто эгч нэгдмэл байдалд ажиллахын зорилго, адислалуудын талаар заахдаа эдгээр жишээг хэрхэн ашигласныг олж мэдэж болох юм. Бид “нэг санаагаар” ажиллахын тулд юу хийж болох вэ?

Хэнри Б.Айринг, “Түүний Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгах нь”

Ариун Сүнсийг хүлээн авах бидний хүсэл болон чадварыг нэмэгдүүлэхийн тулд ерөнхийлөгч Айринг хэд хэдэн туршлагаасаа хуваалцаж, тодорхой удирдамж өгсөн. Түүний туршлагуудыг уншсаныхаа дараа, танай чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн гишүүд Ариун Сүнс тэдний зүрх сэтгэлд хүрсэн эсвэл үнэнийг баталсан, ерөнхийлөгч Айрингийнхтай адил төстэй, ямар дурсамжуудыг хуваалцаж чадах вэ? “Зүрх сэтгэлээ бүхий л амьдралынхаа турш нээлттэй [байлгахад] маань туслахын тулд ерөнхийлөгч Айрингийн хуваалцсан заавар зөвлөгөөг гишүүд самбарт жагсаан бичиж болно. Түүний удирдамжийг дагах нь бидний амьдрал, гэр бүл, чуулга эсвэл Халамжийн нийгэмлэгт хэрхэн туслах вэ?

Даллин Х.Өүкс, “Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс”

Ерөнхийлөгч Өүксийн захиас нь хэрхэн өчүүхэн бөгөөд энгийн зүйлс сайн эсвэл хилэнцэд хүчирхэг нөлөө үзүүлдгийг заасан зүйрлэлүүдийг агуулдаг. Эдгээр зүйрлэлд модны үндэс, сэлүүрчдийн баг, олсны мяндас, дусалж буй ус зэргийг дурдсан. Гишүүд эдгээр зүйрлэлийг уншаад, тэдгээр нь өчүүхэн бөгөөд энгийн зүйлсийг тогтмол хийхийн хүчийн талаар юу заадгийг ярилцаж болно. Ариун Сүнсийн нөлөөг бидний амьдралд авчирдаг өчүүхэн бөгөөд энгийн ямар зүйлс байдаг вэ? Гишүүдийг ерөнхийлөгч Өүксийн зөвлөгөөг дагахын тулд юу хийх хүсэлтэй байгаагаа тунгаан бодоход урь.

Рассэлл М.Нэлсон, “Сүмд зориулсан мөн бидний амьдралд зориулсан илчлэлт”

Ерөнхийлөгч Нэлсон өөрийн захиаст “илчлэлт хүлээн авах сүнслэг чадвараа” нэмэгдүүлэхийг биднээс гуйсан. Гишүүдэд түүний удирдамжийг дагахад нь туслахын тулд та дараахтай төстэй асуултуудыг самбарт бичиж болох юм. Бидэнд илчлэлт яагаад хэрэгтэй вэ? Бид хувь хувьдаа мөн хамтдаа зөвлөлдөх үедээ илчлэлт хүлээн

авах чадвараа хэрхэн нэмэгдүүлж болох вэ? Хэрэв бид илчлэлт эрэлхийлэх юм бол ямар адислалыг ерөнхийлөгч Нэлсон амласан бэ? Гишүүдийг бүлгүүдэд хуваарилж, бүлэг бүрийг эдгээр асуултын нэгд хариулт олж, хуваалцахад урь.

Гэрритт В.Гонг, “Христ энэ өдөр амилсан”

Танай чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн гишүүд ахлагч Гонгийн бидний гэрээнүүдийн болон Аврагчийн Цагаатгалын талаарх захиасаас юу ойлгож мэдэж чадах вэ? Та гишүүдийг захиасыг судалж, Аврагчийн Цагаатгал болон бидний гэрээнүүд хамтдаа ажиллаж, бидэнд санал болгодог адислалуудыг олж мэдэхэд урьж болно. Тэдний юу олж мэдсэн талаар дараах асуултуудыг тавихыг бод. Үүнд: Цагаатгал болон бидний гэрээ бидэнд “боломж олгон, сайжруулахаар” хэрхэн хамтдаа ажилладаг вэ? Тэдгээр нь биднийг юунд итгэлтэй байж, юунаас ангижрахад тусалдаг вэ?

Үлиссэс Соарэс, “Бошиглогчид Ариун Сүнсийн хүчээр ярьдаг”

Ахлагч Соарэсийн захиас бидэнд Их Эзэний хүслийг биелүүлэхдээ өөрсдийн чадварт эргэлзэх үед итгэлтэйгээр үйлдэхэд урамшуулдаг. Ахлагч Соарэс төлөөлөгч гэсэн шинэ дуудлагаа хүлээн авахдаа тайтгарал, баталгааг хэрхэн хүлээн авсан бэ? Тэрээр номлолын ерөнхийлөгчөөр дуудагдсан туршлагаасаа юу мэдэж авсан бэ? Бид түүний туршлагаас юу мэдэж авч болох вэ? Гишүүдэд Их Эзэн тэднийг юу хийгээсэй хэмээн хүсэж байгаа талаар эргэлзэж байсан үеийнхээ туршлагуудаас хуваалцах цаг гаргаж өг. Тэд урагш ахих итгэлийг олж авахын тулд юу хийсэн бэ?

Жэффри Р.Холланд, “Тэдэнтэй хамт байж мөн бэхжүүл”

Танай чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн гишүүд “санваартны болон Халамжийн нийгэмлэгийн тохинууллын арга барил”-д гарсан өөрчлөлтүүдийн талаар олж мэдэхэд тэдэнд ямар ямар асуулт байсан бэ? Тэдгээр асуултад ахлагч Холландын захиас хариултуудыг өгөх болно. Ахлагч Холланд эдгээр өөрчлөлтийн үндэс суурь хэмээн заасан сайн мэдээний зарчмуудыг гишүүд хайж олж болно. Бид түүний захиасаас ямар урилгыг олдог вэ? Ямар ямар адислал амлагдсан бэ? Бидэнд “Христийн жинхэнэ шавь” болоход тохинууллын эдгээр шинэ арга зам хэрхэн тусалж чадах вэ?

Жийн Б.Бингам, “Аврагчийн адил тохинуулах нь”

Бингам эгч өөрийн захиаст тохинуулах хичээл зүтгэлийг маань удирдан чиглүүлэх асуултуудыг өөрсдөдөө тавихад биднийг урьсан. Гишүүд эдгээр асуулт тэдний хичээл зүтгэлийг хэрхэн удирдан чиглүүлэх талаар ярилцаад, Бингам эгчийн асуусан “Тэгэхээр [тохинууллын] ямар ямар жишээ байгаа вэ?” гэсэн асуултын хариултуудыг хайж болно. Та Бингам эгчийн хуваалцсан хувь хүмүүсийн тохинууллын тухай жишээнүүдийн заримыг уншихад цаг гаргаж, гишүүдийг өөрсдийн жишээнээс хуваалцахад урьж болох юм. Бид яагаад мөн хэрхэн тохинуулах талаарх бидний ойлголтыг нэмэгдүүлэх ямар зүйлийг Бингам эгчийн захиасаас олох вэ?

Дийтр Ф.Угдорф, “Энэ Хүнийг харагтун!”

Бид Есүс Христийн цагаатгагч золиослол болон Амилалт нь энэ дэлхийн түүхэн дэх хамгийн чухал үйл явдлууд байсан гэдгийг ойлгоход хэн нэгэнд хэрхэн тусалж болох вэ? Гишүүдийг ахлагч Угдорфын захиасын хэсгүүдийг уншихдаа энэ асуултыг тунгаан бодоход урь. Эдгээр үйл явдал тэдэнд яагаад маш чухал болохыг тайлбарлахад туслах юуг тэд олж болох вэ? Уг ярилцлагын дараа, ангийн гишүүдийг “энэ хүнийг харах” гэдэг нь тэдний хувьд ямар утга учиртай болох талаар ярьж болно. Бид “энэ хүнийг харах” гэдгийг хэрхэн ойлгож мэдсэн бэ?

Квинтин Л.Күк, “Бурхантай уулзахаар бэлтгэ”

Ахлагч Күкийн захиасын талаарх ярилцлагаа эхлүүлэхдээ нэг гишүүнийг Кертландын ариун сүмд санваарын түлхүүрүүд сэргээгдсэн талаар товч ярихад урьж болно. Ахлагч Күкийн захиаст өгүүлснээр, Сүмд эдгээр түлхүүртэй холбоотой ямар ямар үүрэг байдаг вэ? Эдгээр үүрэг Сүмд өнөөдөр хэрхэн илэрхий болгогдсон байдаг вэ? *Зөв шударга байдал, нэгдмэл байдал мөн эрх тэгш байдал* гэсэн үгсийг самбарт бичээд, гишүүдээс ахлагч Күкийн захиасаас эдгээр зарчмын талаар ямар ойлголтыг олж авснаа хуваалцахыг хүс. Эдгээр зарчмыг ойлгох нь Сүмийн эрхэм нандин үүргүүдийг биелүүлэхэд бидэнд хэрхэн тус болох вэ?



Дөрөв дэх ням гаргийн ЦУГЛААНУУД

Сар бүрийн дөрөв дэх ням гарагт ахлагчдын чуулга болон Халамжийн нийгэмлэг нь Тэргүүн Зөвлөл ба Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгаас сонгосон сэдвийг авч хэлэлцэнэ. Дөрөв дэх ням гаргийн сэдэв нь Ерөнхий чуулган болгоноор шинэчлэгдэнэ. Одооноос эхлэн дараагийн Ерөнхий чуулган хүртэл ярилцах сэдэв нь “Бусдад тохинуулах нь” байх болно. Сар бүр удирдагчид эсвэл багш нар тохинуулалтай холбоотой дараах зарчмуудын аль нэгийн талаарх ярилцлагуудыг удирдан явуулахаар сонгох юм.

Тохинууллын талаарх ярилцлагуудад туслах нэмэлт эх сурвалжуудыг ministering.lds.org болон *Лиахона* сэтгүүлийн дараагийн дугааруудад гарах “Тохинууллын зарчмууд” гэсэн өгүүлүүдээс үзнэ үү.

Тохинуулал гэж юу гэсэн үг вэ?

Тохинуулал гэдэг нь танай тойрог эсвэл салбарын гишүүдийн хувьд ямар утгатай вэ? Үүнийг олж мэдэхийн тулд та самбарт *Тохинуулал* гэж бичээд, гишүүдийг тохинуулалтай холбоотой гэж бодож байгаа үгсийг уг үгийг тойруулан бичихэд урь. Гишүүд уг жагсаалтад нэмэх үг хэллэгүүдийг дараах судруудаас олж болно. Үүнд: Матай 25:34–40; Лук 10:25–37; 2 Нифай 25:26; Мозая 18:8–9; 3 Нифай 18:25; мөн Сургаал ба Гэрээ 81:5. Бид эдгээр шүлгээс тохинууллын талаар юу мэдэж авч болох вэ? Та гишүүдийг

гэрчилсэн тохинууллын жишээнээс хуваалцахад урьж болно. Бидний тохинуулал хүмүүсийн сүнслэг болон материаллаг хэрэгцээг хэрхэн хангаж чадах вэ? Энэ нь хүмүүст Христэд ойртоход хэрхэн тусалж чадах вэ?

Аврагч бол тохинууллын төгс үлгэр жишээ.

Хэрхэн илүү үр дүнтэй тохинуулах талаар сурч мэдэхийн тулд гишүүд Аврагчийн бусдад тохинуулсан тухай түүхүүдийг судраас хуваалцаж болно. Иохан 4–6 болон Марк 2:1–12-т хэд хэдэн

жишээ бий. Гишүүд эдгээр түүхээс юу нь тэдэнд гүн сэтгэгдэл төрүүлдэг болон тохиууллын талаар ямар ямар зарчим мэдэж авдгаа хуваалцаж болох юм. Жишээлбэл, Аврагч бусдад үйлчлэхдээ хэрхэн хүн бүрд тохиуулдаг байсан бэ? Тэрээр хүмүүсийн сүнслэг мөн материаллаг хэрэгцээг хэрхэн хангадаг байсан бэ? Ангийн гишүүд хүмүүс эдгээр зарчмыг тохиуулалдаа ашиглаж байгааг гэрчилсэн тохиолдлуудаасаа хуваалцаж болно.

Тохиуулал нь Христийнхтэй адил хайраар урамшуулагддаг.

Та Христийнхтэй адил хайраар урамшуулагдсан тохиууллын хүчийг судлахын тулд самбарт дараах өгүүлбэрүүдийг бичиж, гишүүдийг өгүүлбэрүүдийг гүйцээн бичих хувилбаруудыг санал болгоход урь. *Үүнд: Би үйлчилж буй хүмүүсээ хайрласан үедээ _____.* *Би өөр бусад учир шалтгааны улмаас үйлчлэхдээ _____.* Бид бусдад үзүүлж байгаа тохиууллаа Христийнхтэй адил хайраар урамшуулагдсан байхад анхаарахын тулд юу хийж чадах вэ? Бид тохиуулахаар томилогдсон хүмүүсээ хайрлах Христийнхтэй адил хайрыг хэрхэн хөгжүүлдэг вэ? (Моронай 7:45–48-ыг үзнэ үү). Гишүүд Христийнхтэй адил хайраар өдөөгдсөн тохиууллын жишээг хуваалцаж болно.

Бурхан бүх хүүхдээ асран хамгаалуулаасай хэмээн хүсдэг.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон хэлэхдээ “Их Эзэний үнэн бөгөөд амьд Сүмийн таних тэмдэг үргэлж Бурханы хүүхэд тус бүрд болон тэдний гэр бүлүүдэд тохиуулах зохион байгуулалттай, чиглүүлсэн хүчин чармайлт байх болно” гэсэн (“Бурханы хүч, эрх мэдлээр тохиуулах нь,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган). Сүм бидэнд хувь хүн бүрийг илүү сайн халамжлахад тусалдаг “зохион байгуулалттай, чиглүүлсэн” ямар арга замуудын заримыг ерөнхийлөгч Нэлсон заасан бэ? Яагаад эдгээр хүчин чармайлт “Их Эзэний үнэн бөгөөд амьд Сүмийн таних тэмдэг” байдаг вэ? (Мозая 18:21–22 болон Моронай 6:4–6-аас зарим санааг авна уу). Хүмүүс Сүмийн дуудлага эсвэл үүрэг даалгавраа гүйцэтгэхдээ тохиуулж байсан учраас бидний болон бусдын амьдралд ямар адислал ирсэн бэ?

Бодгалиудын үнэ цэн Бурханы мэлмийд агуу юм.

Мозаягийн хөвгүүдийн туршлага бидний хүмүүст хандах арга барил тэдэнд хэрхэн тохиуулахад нөлөөлдөг болохыг

харуулдаг. Та самбарт *Нифайчууд леменчүүдэд хэрхэн ханддаг байсан* болон *Мозаягийн хөвгүүд леменчүүдэд хэрхэн ханддаг байсан* гэж бичиж болно. Тэгээд ангийн гишүүдийг Мозая 28:1–3 болон Алма 26:23–26-аас эдгээр өгүүлбэр тус бүрийн доор бичих үг хэллэгүүдийг хайж олоход урь. Энэ харьцуулалт бидний хүмүүст хандах арга барил тэдэнд тохиуулах арга замуудад маань хэрхэн нөлөөлдөг талаар юу зааж байна вэ? Бид хүмүүсийг ихэнхдээ Бурханы мэлмийгээр хардаг байхад хэрхэн суралцах вэ? (С ба Г 18:10–16-г үзнэ үү).

Жинхэнэ тохиуулагчид бусдын хэрэгцээнд анхаарлаа төвлөрүүлдэг.

Бид тохиуулахдаа бусдын хэрэгцээнд анхаарлаа төвлөрүүлэхийн үнэ цэнийг илүү сайн ойлгоход нь гишүүдэд туслахын тулд тохиууллыг бэлэг өгөх болон хүлээн авахтай харьцуулж болох юм. Бидэнд юу хэрэгтэйг эсвэл юу хүссэнийг маань мэддэг хэн нэгнээс бид утга учиртай бэлэг хүлээн авч байсан уу? Тохиуулах нь утга учиртай бэлэг өгөхтэй хэрхэн адил төстэй вэ? Хамгийн сүүлийн Ерөнхий чуулганаас хүмүүс бусдын хэрэгцээний дагуу хэрхэн тохиуулсан тухай түүхүүдийг ярилцахыг бод (жишээ болгон 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулганы материалаас Жийн Б.Бингамын “Аврагчийн адил тохиуулах нь” үгийг үзнэ үү). Гишүүд мөн энэ зарчмыг харуулсан бусад түүхийг хуваалцаж болно.

Бид бусдын хэрэгцээ юу болохыг хэрхэн мэдэх вэ? Гишүүдийг тохиуулдаг зарим хүмүүсээ жагсаан бичихэд урь. Тэд нэр бүрийн хажууд “Энэ хүнд Христэд илүү ойртоход нь юу хэрэгтэй вэ?” гэсэн асуултад хариулан бичиж болно. Боломжтой бол гишүүдийг хүн бүрийн хүлээн авах хэрэгтэй байгаа ёслолуудыг бичихэд урамшуул. Гишүүдийг энэ асуултын талаар үргэлжлүүлэн бодож, бусдын хэрэгцээг хангахад нь туслах сүнслэг удирдамжийг илэрхийлэхэд урь.

Их Эзэн биднийг бусдын тохиууллыг хүлээн авахыг зөвшөөрөхийг хүсдэг.

Ахлагч Роберт Д.Хэйлс “Сайн мэдээний төлөвлөгөө нь өгөх болон хүлээн авахыг шаарддаг. . . . Хүнд хэцүү байдалд байгаа хувь хүмүүс ‘Би энэ бэрхшээлийг ганцаараа туулж чадна,’ . . . ‘Би өөрийгөө халамжилж чадна’ гэж ихэнхдээ хэлдэг. Хэн ч өөр нэгний тусламж хэрэггүй байхаар тийм баян биш, хэн ч бусдадаа зарим байдлаар тус болохооргүй туйлын ядуу байдаггүй гэж

нэгэнтээ хэлсэн байдаг. Бусдаас итгэлтэйгээр тусламж гуйх болон нинжин сэтгэлээр туслах зан чанар нь бидний төрөлх мөн чанарын нэг хэсэг байх ёстой” (“We Can’t Do It Alone,” *Ensign*, Nov. 1975, 91, 93). Бид яагаад заримдаа бусдаас тусламж авахдаа тээнэгэлздэг вэ? Бидний тусламж авах хүсэл бидэнд үйлчилдэг хүмүүсийг хэрхэн адисалдаг вэ? Гишүүдэд бусдын тохиууллыг хүлээн авахдаа илүү нээлттэй байж чадах арга замуудыг тунгаан бодох хэдэн хором өг. Бид яагаад бие биендээ хэрэгтэй байдаг талаар 1 Коринт 12:13–21-д юу гэж хэлсэн бэ?

Бид олон арга замаар бусдад тохиуулж чадна.

Бидний нэг нэгэндээ тохиуулж болох олон арга замыг бодож үзэхэд нь гишүүдэд туслахын тулд та тэднийг ахлагч Жэффри Р.Холландын “Тэдэнтэй хамт байж мөн бэхжүүл” захиасыг уншихад урьж болно (2018 оны 4-р сарын Ерөнхий чуулганы материал мөн Лиахона сэтгүүлийн дараагийн дугааруудад гарах “Тохиууллын зарчмууд”-ыг үзнэ үү). Гишүүд цөөн хүнтэй бүлгүүдэд хуваарилагдан, бүлэг бүр хэн нэгэнд тусламж хэрэгтэй байж болох хэд хэдэн тохиолдлыг бодож олж болох юм. Тэгээд тэд тухайн тохиолдолд хувь хүмүүсийн сүнслэг болон материаллаг хэрэгцээнд нийцүүлэн тохиуулах арга замуудын талаар хамтаараа хэлэлцэж болно. Бүлгүүдийг өөрсдийн санааг хуваалцаж, тэдний тохиуулдаг хүмүүсийг дээрх санааны аль нэг нь адисалж болох эсэхийг тунгаахыг хүс.



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ